

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Бодлогын судалгаа шинжилгээний төв ТБОНӨҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2024/65/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn	Санхүү-Нийцлийн хэлтсийн дарга, аудитын менежер: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Улаанбаатар хот 2024 он	Аудитын менежер: С.Гантөгс Утас: 325093 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn Ахлах аудитор: Н.Энхмэнд Утас: 325093 Цахим хаяг: enkhmendn@audit.gov.mn Аудитор: Н.Түмэнжаргал Утас: 325093 Цахим хаяг: Tumenjargaln@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.03.15 № 601
танай _____-ны № _____-Т

НИЙСЛЭЛИЙН БОДЛОГЫН
СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ДАРГА, Р.ДАГВА ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Бодлогын судалгаа шинжилгээний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Бодлогын судалгаа шинжилгээний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус хэлтсийн талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлд тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий удирдлагын шийдвэр, ажил гүйлгээ, үйл явдал үүсээгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшний боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>10,563,890.00</u>	<u>11,586,690.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	10,563,890.00	11,586,690.00
354	Хангамжийн материал	10,563,890.00	11,586,690.00
35410	Бичиг хэргийн материал	00.00	426,600.00
35420	Аж ахуйн материал	00.00	296,500.00
35470	Бусад хангамжийн материал	10,563,890.00	10,863,590.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>239,247,177.88</u>	<u>2,137,869,476.41</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	239,247,177.88	2,137,869,476.41
392	Биет хөрөнгө	238,059,177.88	350,114,096.11
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	202,092,287.00	351,452,800.53
39206	Хуримтлагдсан элэгдэл	-11,937,215.84	-62,073,194.57
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51,327,900.00	77,270,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,423,793.28	-16,536,009.85
393	Биет бус хөрөнгө	1,188,000.00	1,787,755,380.30
39301	Програм хангамж	1,320,000.00	1,801,247,842.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-132,000.00	-13,492,461.70
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>249,811,067.88</u>	<u>2,149,456,166.41</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>4,800,000.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,800,000.00	00.00
413	Өглөг	4,800,000.00	00.00
4136	Бусад өглөг	4,800,000.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	4,800,000.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>245,011,067.88</u>	<u>2,149,456,166.41</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	245,011,067.88	2,149,456,166.41
512	Хуримтлагдсан үр дүн	245,011,067.88	2,149,456,166.41
51210	Өмнөх үеийн үр дүн	245,011,067.88	245,011,067.88
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,904,445,098.53
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>249,811,067.88</u>	<u>2,149,456,166.41</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	804,940,000.00	5,549,327,994.47
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	804,940,000.00	5,549,327,994.47
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	290,783,360.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	290,783,360.00

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	804,940,000.00	3,458,616,792.47
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	804,940,000.00	3,458,616,792.47
1330	Төсвийн захирагчдаас	00.00	1,799,927,842.00
133003	Хөрөнгийн	00.00	1,799,927,842.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	559,928,932.12	3,644,882,895.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	559,928,932.12	3,644,882,895.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	534,515,553.38	3,638,192,201.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	248,299,045.83	1,232,253,274.48
210101	Үндсэн цалин	233,470,698.00	708,476,877.26
210102	Нэмэгдэл	9,213,348.00	79,142,397.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,614,999.83	23,180,000.00
210104	Урамшуулал	00.00	419,825,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	1,629,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,602,736.43	152,493,181.46
210201	Тэтгэврийн даатгал	20,680,734.59	104,648,525.85
210202	Тэтгэмжийн даатгал	2,480,500.46	12,311,591.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,984,400.37	9,849,273.04
210204	Ажилгүйдлийн даатгал	496,100.09	1,524,526.47
210205	Эрүүл мэндийн даатгал	4,961,000.92	24,159,264.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,869,552.00	9,244,558.00
210304	Байрны түрээс	3,869,552.00	9,244,558.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,410,600.00	63,126,400.00
210401	Бичиг хэрэг	4,051,820.00	8,425,400.00
210402	Тээвэр, шатахуун	5,979,400.00	12,758,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,240,000.00	23,760,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	5,520,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,139,380.00	12,661,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	3,861,000.00
210604	Урсгал засвар	00.00	3,861,000.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	275,496,396.00
210702	Дотоод албан томилолт	00.00	2,406,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	273,090,396.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	214,840,610.00	1,783,047,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	209,985,610.00	1,769,802,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,800,000.00	4,800,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	55,000.00	8,445,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,493,009.12	118,669,892.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	6,102,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	35,959,235.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,493,009.12	76,608,657.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,413,378.74	6,690,694.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	5,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	5,500,000.00

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	23,913,378.74	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,913,378.74	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	1,190,694.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	245,011,067.88	1,904,445,098.53
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	245,011,067.88	1,904,445,098.53

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	804,940,000.00	5,549,327,994.47
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	804,940,000.00	5,549,327,994.47
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	290,783,360.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	290,783,360.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	804,940,000.00	3,458,616,792.47
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	804,940,000.00	3,458,616,792.47
1330	Төсвийн захирагчдаас	00.00	1,799,927,842.00
133003	Хөрөнгийн	00.00	1,799,927,842.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	550,199,813.00	3,574,097,038.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	550,199,813.00	3,574,097,038.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	524,786,434.26	3,567,406,344.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	248,299,045.83	1,232,253,274.48
210101	Үндсэн цалин	203,188,708.83	708,476,877.26
210102	Нэмэгдэл	33,830,337.00	79,142,397.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,280,000.00	23,180,000.00
210104	Урамшуулал	00.00	419,825,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	1,629,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,602,736.43	152,493,181.46
210201	Тэтгэврийн даатгал	20,680,734.57	104,648,525.85
210202	Тэтгэмжийн даатгал	2,480,500.46	12,311,591.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,984,400.39	9,849,273.04
210204	Ажилгүйдлийн даатгал	496,100.09	1,524,526.47
210205	Эрүүл мэндийн даатгал	4,961,000.92	24,159,264.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,869,552.00	9,244,558.00
210304	Байрны түрээс	3,869,552.00	9,244,558.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,879,490.00	63,849,500.00
210401	Бичиг хэрэг	3,949,200.00	8,852,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,979,400.00	12,758,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,240,000.00	23,760,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	5,520,900.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,710,890.00	12,957,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	62,045,000.00	4,160,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	299,700.00
210604	Урсгал засвар	62,045,000.00	3,861,000.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	275,496,396.00
210702	Дотоод албан томилолт	00.00	2,406,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	273,090,396.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	155,090,610.00	1,787,847,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	155,035,610.00	1,769,802,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	9,600,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	55,000.00	8,445,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	42,061,235.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	6,102,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	35,959,235.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,413,378.74	6,690,694.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	5,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	5,500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	23,913,378.74	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,913,378.74	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	1,190,694.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	254,740,187.00	1,975,230,955.53
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	254,740,187.00	1,975,230,955.53
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	254,740,187.00	1,975,230,955.53
2200	Дотоод эх үүсвэрээр	254,740,187.00	1,975,230,955.53
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	254,740,187.00	1,975,230,955.53
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-254,740,187.00	-1,975,230,955.53

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	245,011,067.88	245,011,067.88
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	245,011,067.88	245,011,067.88
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	245,011,067.88	245,011,067.88
D08	Тайлант үеийн үр дүн	1,904,445,098.53	1,904,445,098.53

D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,149,456,166.41	2,149,456,166.41
-----	--	------------------	------------------

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,210,992,500.00	3,458,616,792.47	752,375,707.53	82.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,210,992,500.00	3,458,616,792.47	752,375,707.53	82.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,155,992,500.00	3,453,116,792.47	702,875,707.53	83.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,311,140,000.00	1,196,378,274.48	114,761,725.52	91.2
210101	Үндсэн цалин	673,000,000.00	672,601,877.26	398,122.74	99.9
210102	Нэмэгдэл	72,600,000.00	79,142,397.22	-6,542,397.22	109.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,300,000.00	23,180,000.00	13,120,000.00	63.9
210104	Урамшуулал	529,240,000.00	419,825,000.00	109,415,000.00	79.3
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	1,629,000.00	-1,629,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	164,202,500.00	148,050,056.46	16,152,443.54	90.2
210201	Тэтгэврийн даатгал	111,756,900.00	101,599,150.85	10,157,749.15	90.9
210202	Тэтгэмжийн даатгал	13,111,400.00	11,952,841.30	1,158,558.70	91.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,489,100.00	9,562,273.04	926,826.96	91.2
210204	Ажилгүйдлийн даатгал	2,622,300.00	1,456,526.47	1,165,773.53	55.5
210205	Эрүүл мэндийн даатгал	26,222,800.00	23,479,264.80	2,743,535.20	89.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,800,000.00	9,244,558.00	1,555,442.00	85.6
210304	Байрны түрээс	10,800,000.00	9,244,558.00	1,555,442.00	85.6
2104	Хангамж, бараа материалын зардал	75,580,000.00	63,849,500.00	11,730,500.00	84.5
210401	Бичиг хэрэг	9,000,000.00	8,852,000.00	148,000.00	98.4
210402	Тээвэр, шатахуун	13,940,000.00	12,758,850.00	1,181,150.00	91.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	33,990,000.00	23,760,000.00	10,230,000.00	69.9
210404	Ном, хэвлэл	5,450,000.00	5,520,900.00	-70,900.00	101.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,200,000.00	12,957,750.00	242,250.00	98.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	258,700,000.00	179,463,813.53	79,236,186.47	69.4

210601	Багаж, техник, хэрэгсэл	165,400,000.00	160,460,213.53	4,939,786.47	97.0
210602	Тавилга	18,100,000.00	15,142,600.00	2,957,400.00	83.7
210604	Урсгал засвар	75,200,000.00	3,861,000.00	71,339,000.00	5.1
2107	Томилолт, зочны зардал	291,200,000.00	187,031,090.00	104,168,910.00	64.2
210702	Дотоод албан томилолт	30,000,000.00	00.00	30,000,000.00	0.0
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	261,200,000.00	187,031,090.00	74,168,910.00	71.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,036,120,000.00	1,662,997,500.00	373,122,500.00	81.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,994,520,000.00	1,644,952,000.00	349,568,000.00	82.5
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,600,000.00	9,600,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	32,000,000.00	8,445,500.00	23,554,500.00	26.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,250,000.00	6,102,000.00	2,148,000.00	74.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00	6,102,000.00	1,898,000.00	76.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	250,000.00	00.00	250,000.00	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,000,000.00	5,500,000.00	49,500,000.00	10.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	55,000,000.00	5,500,000.00	49,500,000.00	10.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	55,000,000.00	5,500,000.00	49,500,000.00	10.0
132	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,210,992,500.00	3,458,616,792.47	752,375,707.53	82.1
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,210,992,500.00	3,458,616,792.47	752,375,707.53	82.1
132001	Орон нутгийн төсвөөс	4,210,992,500.00	3,458,616,792.47	752,375,707.53	82.1
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	30	21	9	70.0
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	29	20	9	69.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	289,592,666.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	289,592,666.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	289,592,666.00

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	35,875,000.00
210101	Үндсэн цалин	35,875,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,443,125.00
210201	Тэтгэврийн даатгал	3,049,375.00
210202	Тэтгэмжийн даатгал	358,750.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	287,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	68,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	680,000.00
2107	Томилолт, зочны зардал	88,465,306.00
210702	Дотоод албан томилолт	2,406,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	86,059,306.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	124,850,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	124,850,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,959,235.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	35,959,235.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	290,783,360.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	290,783,360.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	290,783,360.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,487.0 мянган төгрөгийн 5 зөрчил¹ илэрснийг арилгуулах 5,487.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж, 3 албан шаардлагыг хүргүүллээ.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусдаар гүйцэтгүүлсэн 1,769,802.0 мянган төгрөгийн судалгаануудыг шууд зардлаар тусгасан, НБББББ-н баримт бичгийг байгууллагын онцлогт тохируулж судалгааг ашиглах хугацаа, үнэ цэнээр нь ангилж биет бус хөрөнгөд бүртгэх талаар арга хэмжээ авч ажиллах хэрэгтэй байна.	1	-					1	-				
2023.10.18-ны өдөр сургалтын байр, өдрийн цайны мөнгийг шууд зардлаар тусгаж зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэл дутуу.	1	3,095.0			1	3,095.0						
Үндсэн хөрөнгийн тооллогыг хийхдээ зарим хөрөнгийг дутуу тоолсон, үндсэн хөрөнгийн	1	2,392.0					1	2,392.0				

тооллогын бүртгэл блансын дүнгээс зөрүүтэй байсан.												
Дүн	3	5,487.0	-	-	1	3,095.0	2	2,392.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим сайтад тайлант хугацааны 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	1	-			1	-		
2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Багц ажлыг босго үнээс доош болгон хувааж, албан тооттой үнийн санал авахгүй, шууд гэрээ байгуулсан байна.	1	254,340.4			1	254,340.4		
Дүн	2	254,340.4			2	254,340.4		